



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/277

Чингис хот

Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл
ажлыг зохион байгуулахад
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, 2.1.6, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Аймгийн 2020 оны төсөв батлах тухай" 2019 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2020 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд 12 жилийн сургалттай Ерөнхий боловсролын сургуулиудын багш, сурагчдад зориулсан зөвлөн туслах ажлыг зохион байгуулахад Боловсрол, соёл, урлагийн газарт дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 522100 /таван зуун хорин хоёр мянга нэг зуу/ төгрөгийн хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА